

ТҮҮЧЭЭ ТЭРЭГ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ С.ДАГВАСАМБУУ

БАТЛАВ  
УРГАМАЛ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Г.ГЭРЭЛТ-ОД

2021 оны 10 сарын 22 өдөр

## ЗАВХАН АЙМГИЙН УРГАМАЛ СУМААС “ТҮҮЧЭЭ ТЭРЭГ” ХХК-ТАЙ БАЙГУУЛАХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

2021 оны 10 сарын 22-ны өдөр

Ургамал сум

Энэхүү гэрээг нэг талаас Завхан аймгийн Ургамал сумын нутгий захиргааны байгууллагыг төлөөлж Засаг даргын Тамгын газрын дарга Мөнхнастын Өсөхбаяр, нөгөө талаас **MV-021183** дугаар бүхий ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Түүчээ тэрэг ХХК-ийг төлөөлж захирал С.Дагвасамбуу (цаашид Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэх) нар (цаашид “Талууд “ гэх) дараах нөхцлөөр харилцан тохиролцож Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Завхан аймгийн Ургамал суманд байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолд “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” нь байгаль орчныг хамгаалах, уурхай, ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллана” гэсэн заалт нь гэрээний нийтлэг үндэслэл болно.

1.2. Энэхүү гэрээ нь Завхан аймгийн Ургамал сумын Тосгуур багийн нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, уурхайн үйл ажиллагаанаас бий болох хөгжлийн боломжуудыг сумын иргэд хүртэх, хүн ам, мал аж ахуй байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг стандартад заасан хамгийн бага хэмжээнд байлгах, нөлөөлөлд өртсөн айл өрх, иргэдийн хохирол, эрсдлийг барагдуулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, орон нутгийн удирдлага, нутгийн иргэд, компанийн хооронд ил тод, шударга, нээлттэй хамтран ажиллах харилцааг зохицуулна.

1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбайд орших Завхан аймгийн ургамал сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

1.4. Гэрээний хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр талууд хамтран баталж хэрэгжүүлнэ.

## **ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗАРЧМУУД**

2.1. Гэрээний талууд гэрээг тайлбарлах, хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, тэгш оролцоотой байх, шударга ёсыг сахих, харилцан ашигтай, ил тод, нээлттэй байх, шударгаар сахин биелүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

2.2. Ургамал сумын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор талууд хүлээсэн үүргээ биелүүлэх, түүнд хяналт тавих, тулгамдаж буй асуудалд нэн тэргүүнд анхаарал хандуулах, шаардлагатай зүйлсийн талаар нэгдсэн ойлголтыг бий болгон хамтран ажиллах.

## **ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

### **3.1. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр сумын ЗДТГазрын эрх, үүрэг**

3.1.1. Байгаль орчныг хамгаалах талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн биелэлтэнд холбогдох хууль, тогтоомжинд заасны дагуу хяналт лтавьж зөрчил гаргасан гэм буруутай этгээдэд хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хариуцлага хүлээлгэх буюу хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах, шүүхэд нэхэмжлэл гаргах.

3.1.2. Энэхүү гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах.

3.1.3. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах.

3.1.4. Осол болон бусад шалтгаанаар байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйц нөхцөл байдал бий болсон тохиолдолд уурхайн талбайд эрх бүхий албан тушаалтнууд болон томилогдсон албан тушаалтнууд саадгүй нэвтрэн орж хяналт, шалгалт хийх.

3.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирсан хохирлыг арилгах, нөхөн сэргээлт хийлгэх, дүйцүүлэн хамгаалах ажлыг жил бүр төлөвлөж хийнэ.

3.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээнд болон бусад хэлэлцээрээр тохиролцсон ажлууд болон холбогдох хууль тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй тохиолдолд компани уг үүргээ биелүүлэх хүртэл хууль тогтоомжинд заасан үндэслэлээр тусгай зөвшөөрөл

эзэмшигчид төсөлтэй холбоотой зөвшөөрөл (газар, ус ашиглах ..... гэх мэт), тусгай зөвшөөрлүүдэд хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг зогсоох хүртэлх арга хэмжээг авах ажлыг зохион байгуулна.

3.1.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох хууль болон энэ гэрээгээр хүлээсэн байгаль орчны үүрэгтэй холбогдуулан Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн тайлан, мэдээллийг тухай бүр нь хүлээн авч танилцан нийтэд мэдээлэл хийнэ.

3.1.8.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанаас бий болсон хог хаягдал, бохир ус зайлуулах цэгийг тогтоон өгч хяналт тавьж ажиллана.

3.1.9.Талуудын хамтын ажиллагаа, гэрээний хэрэгжилтийг, зохицуулах чиглэлээр хууль эрх зүйн мэдлэг мэргэжилтэй төлөөлөгч томилж ажиллуулж болно.

3.1.10.Мэргэжлийн байгууллагаас ус олгох боломжгүй гэсэн дүгнэлт гарвал сумын зүгээс ус олгохгүй.

3.1.11.Уурхайн усны өдөр тутмын хэрэглээнд сум, багаас хяналт тавьж ажиллах ба шаардлагатай тохиолдолд зогсооно.

3.1.12 .Усны тухай хуулийн 28.6 зүйлд заасныг үндэслэн 50 м3-ээс ихгүй усыг сумын Засаг даргын шийдвэрээр олгож болно.

## **3.2.Байгаль орчныг хамгаалах чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

3.2.1.Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудад заасан эрх эдэлж, үүрэг хүлээх ба байгаль орчны холбогдолтой Монгол Улсын стандарт, нормыг ханган ажиллах.

3.2.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэрэгжүүлж буй төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн хуулбар хувийг Ургамал сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлж мөрдөж ажиллах.

3.2.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь сумын төлөөллийн оролцоотойгоор улирал тутамд уурхай орчмын хөрс, ус агаараас дээж авах, мэргэжлийн байгууллагаар шинжлүүлэх, шинжилгээний дүн, тайланг сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлэх.

3.2.4.Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан 10 гол зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлж дараа жилийн менежментийн төлөвлөгөөнд сумын саналыг тусгах.

3.2.5.Экологийн боловсрол, хүмүүжил олгох чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллага болон тухайн чиглэлээр сум үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх.

3.2.6.Сумын цөлжилттэй тэмцэхэд зориулж жил бүр үр дүнтэй ажил зохион байгуулж, санхүүгийн болон холбогдох дэмжлэг үзүүлэх.

3.2.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн олборлолт явуулах зорилгоор газрын хөрс эвдэгдсэн тохиолдолд нөхөн сэргээлт хийнэ.

3.2.8.Аялал, жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх.

3.2.9.Гэрээнд заасан бусад асуудлыг биелүүлэх.

3.2.10.Тусгай зөвшөөрөл эзэмшигч сумын захиргаанд дараах тайлан мэдээ, тайланг хүргүүлнэ.

а.Сумаас ашиглаж буй гүний худгийн усны түвшинд сар бүр мониторинг хийж, мэдээг улирал тутамд сумын ЗДТГазарт хүргүүлэх.

б.Тухайн жилд төсөлд ашиглагдах химийн болон аюултай бодис, шатах тослох материалын жагсаалтыг жил бүрийн эхний улиралд бэлтгэн орон нутгийн захиргаанд хүргүүлэх.

в.Засгийн газрын холбогдох байгууллага, албан тушаалтанд заавал тайлагнах ёстой байгаль орчинд сөрөг нөлөө бүхий осол, эрсдэл, түүний үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлангийн хувийг сумын Засаг даргын Тамгын газарт гаргаж өгөх.

г.Тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар орон нутгийн захиргаанд мэдээллэх.

3.2.11.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс ашиглалтын үйл ажиллагаа явуулаад эдийн засгийн хувьд ашиггүй гэж үзсэн талбайд нөхөн сэргээлт хийхээс өмнө ЗДТГ-т мэдэгдэнэ.

### **3.3.Сумын хөгжлийг дэмжих чиглэлээр сумын ЗДТГ-ын эрх, үүрэг**

3.3.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс зарлагдсан ажлын байрыг сумын иргэдэд нээлттэй мэдээлэх, сонгон шалгаруулалтанд сумаас ажиллах нэр дэвшигчдийн талаар санал өгөх, саналын хэрэгжилтийн талаар мэдээлэл хүлээн авах.

3.3.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нийлүүлэх худалдан авалтыг талаарх мэдээллийг аж ахуй нэгж, ард иргэдэд нээлттэй мэдээлэх.

3.3.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс үзүүлсэн аливаа дэмжлэгийг аймаг, сумын нийгэм эдийн засгийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа явуулах, хяналттайгаар захиран зарцуулах, олон нийтэд тайлагнах.

**3.4.Сумын хөгжлийг дэмжих чиглэлээр Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүрэг.**

3.4.1.Үйл ажиллагаагаа хэвийн тасралтгүй нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу ЗДТГазарт тавьж шийдвэрлүүлэх.

3.4.2.Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтанд хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллгатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах.

3.4.3.Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах.

3.4.4.Ажиллагсдын цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлж Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бусад уул уурхайн жишиг цалинтай дүйцэхүйц хэмжээнд хүргэх.

3.4.5.Өөрсдийн санаачлагаар жижиг дунд үйлдвэр байгуулан ажиллаж байгаа сумын харъяалалтай иргэд, малчид, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, нөхөрлөлийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тэдний үйлдвэрлэсэн бараа, ажил үйлчилгээг худалдан авах замаар ажлын байр нэмэгдүүлэх.

3.4.6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч ажил үйлчилгээ, худалдан авалтын нэр, төрөлд өөрчлөлт орох бүрт хэрэгцээт бараа, бусад бүтээгдэхүүнүүдийн болон ажил үйлчилгээний жагсаалтыг сумын ЗДТГазарт хүргүүлж, орон нутгаас батлан гаргасан хуваарийн дагуу аж ахуйн нэгж багуудын малчидтай хамтран ажилласан, тайланг нээлттэй мэдээлэх.

3.4.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийт ажлын байрны 30-с доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг (албан ёсны харъяалалтай) зохих түвшний сургалтанд хамруулсаны үндсэн дээр ажиллуулах.

3.4.8.Уурхайд ашиглаж байгаа нийт тээврийн хэрэгслийг аймгийн Авто тээврийн газарт бүртгүүлж, жил бүрийн үзлэг оношлогоонд хамруулах арга хэмжээг орон нутгийн байгууллагаар гүйцэтгүүлэх.

3.4.9. Уурхайд хэрэгцээтэй сүү, цагаан идээ, мах, махан бүтээгдэхүүн, төмс хүнсний ногоо болон хүнсний хэрэгцээт бусад бүтээгдэхүүнийг сумаас шууд худалдан авалт хийх./ бүх аж ахуй нэгжийг тэгш хамруулах/

3.4.10. Тосгуур багийн малчдаас Уурхайд хэрэгцээтэй мал мах худалдан авалт хийх.

3.4.11. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбай орших аймаг, сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.4.12. Сумын иргэдийг нарийн мэргэжлийн сургалтанд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зардлаар хамруулах, ажлын байран дээр дэвших боломжийг тогтмол бүрдүүлэх.

3.4.13 Сар бүрын 28-ны дотор ажлын явцаа тайлагнаж ажиллана.

### **3.5. Дэд бүтэц, нийгмийн асуудлын талаар ЗДТГазрын эрх, үүрэг**

3.5.1. Шаардлагатай тохиолдолд уурхайд эмнэлэг, харилцаа холбоо, цагдаа, соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх.

3.5.2. Уул уурхайн ажиллагаанд шаардлагатай зам, харилцаа холбоо, эрчим хүчний байгууламж, барихад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих.

3.5.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжид ажиллагсдын хөдөлмөрлөх нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахад анхаарч хөдөлмөрийн гэрээг байгуулан ажиллуулж түүнд хяналт тавих.

3.5.4. Оюутан, залуучууд, эмэгтэйчүүд, малчид, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд багачууд зэрэг зорилтот бүлгүүдэд хандсан төсөл хөтөлбөрүүдийг тусгай зөвшөөрөл эзэмшигч хамтранг хэрэгжүүлэх.

### **3.6. Дэд бүтэц, нийгмийн асуудлын талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

3.6.1. Тусгай зөвшөөрөл бүхий талбайд орших эртний булш, бунхан, түүх, соёлын дурсгалт зүйлс, орон нутгийн иргэдийн тахин шүтдэг, соёл зан заншлын ач холбогдол бүхий газруудыг хөндөхгүй байх, хөндөгдсөн тохиолдолд нүүлгэн шилжүүлж, авран хамгаалах.

3.6.2. Уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртсөн айл өрхүүдэд учирсан хохирлыг нөхөн төлөх, тэднийг нүүлгэн шилжүүлж, дэмжлэг үзүүлэх.

3.6.3.Нөлөөнд өртөж байгаа малчдын өвөлжөө, хаваржаа орчин тойрон дахь малын бэлчээр, хадлангийн талбай, худаг, ундны усны эх үүсвэрт хохирол учруулахгүй байх, тэдгээрт үзүүлсэн нөлөөллийг эрх бүхий байгууллагаар тогтоолгон тэдэнд учирсан хохирлын нөхөн олговрыг олгох буюу түүнтэй адилтгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

3.6.4.Ган, зуд, халдварт өвчин, гэнэтийн аюул осол зэрэг давагдашгүй хүчин зүйлүүдэд өртсөн тохиолдолд орон нутгийн захиргаатай хамтран нийгмийн хариуцлагыг ухамсарлах, дэмжлэг туслалцаа үзүүлэх. [эд материал унаа техник, бензин шатахуун,хүн хүч, хөрөнгө санхүүгийн эх оүүсвэр гаргах гэх мэт]

3.6.5.Малчдын өвөлжөө, хаваржаа худгийг нүүлгэн шилжүүлэхэд олгосон нөхөн олговор болон худаг, ус, бэлчээртээ хүрэх замыг хааж боогдуулснаас өөр эх үүсвэр бий болгоход гарсан зардлыг олгох ба үнэн зөвөөр тайлагнах.

3.6.6.Бэлчээрийг эрсдлээс хамгаалах зорилгоор малын усан хангамж, уст цэгийг нэмэгдүүлэх, засварлах, малын тэжээлийн ургамлыг тариалж өвс, тэжээлийн фондтой болгоход дэмжлэг үзүүлэх.

3.6.7.Дэд бүтэц, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын төрийн болон төрийн бус байгууллагуудтай гэрээний үндсэн дээр хамтран ажиллах гэрээний биелэлтийн талаарх тайланг сумын ЗДТГазар, ИТХ-д хүргүүлэх.

3.6.8.Аймаг, улс, тив, дэлхийн тэмцээн уралдаан, урлаг спортын арга хэмжээнд оролцох орон нутгийн харъяат болон уугуул тамирчдыг дэмжих.

3.6.9.Нийгмийн хариуцлагын хүрээнд суманд оруулж буй хөрөнгө оруулалтуудыг үр өгөөжтэй, цаашид ашиглах зардлыг сум хариуцаж явахад боломжтой байхуйцаар судалгааг хийж сумтай зөвшилцөн барьж байгуулж хүлээлгэн өгч байх, мөн холбогдох зардлын тооцоог ил тод нээлттэй тайлагнах.

3.6.10.Нийтээр тэмдэглэх баяр наадам болон чуулга уулзалт, зөвлөгөөн, сумаас төрөн гарч байгаа алдартнуудыг алдаршуулах, шашны томоохон зан үйл, байгаль цаг агаарт нөлөөлөх шинжлэх ухааны бодит хөрөнгө оруулалт шаардагдах зэрэг арга хэмжээг зохион байгуулахад хамтран ажиллаж санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

3.6.11.Хог хаягдлын нэгдсэн цэг болон гүүрний ашиглалт хамгаалалтанд тогтмол анхаарч тодорхой арга хэмжээг Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлэх.

3.6.12.Дэд бүтэц бүтээн байгуулалттай холбоотой ажлуудад техникийн тусламж дэмжлэг үзүүлэх.

### **3.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 2021 онд хийж хэрэгжүүлэх ажил**

3.7.1.Тус сумын ЗДТГ-т нутгийн зөвлөлийн дансаар дамжуулан орон нутгийн хөгжилд 25.000.000, Тосгуур багт бүтээн байгуулалтын ажил хийсэн компаний дансруу 25.000,000 сая төгрөгийг тус тус 1.....,2.....дансаар 2021 оны 12 сарын 15-нй дотор багтаан шилжүүлнэ.

3.7.2.Хогийн цэгийг өөрийн техник хэрэгслээр 2021 оны 09 сарын 28-аас 30-ны дотор түрж булшлана.

3.7.3.Дүйцүүлэн хамгаалалтын ажлын хүрээнд Намгын ард 0,5 га, сумын төвд байрлах 2,5 га ногоон хайсыг төмөр хайсаар солих ажлыг 2022 оны 05 сарын 01-ны дотор хийж гүйцэтгэх.

3.7.4 Сумаас хангах бололцоотой ажлын байранд сумын иргэнийг заавал авч ажиллуулсан байх 2021 оны 11 сарын 30-ны дотор.

### **Дөрөв. Хамтын ажиллагааны хороо**

4.1.Талуудын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид “хороо” гэх)-г ЗДТГазар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2.Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг иргэдийн нийтийн хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3.Гэрээг байгуулсан ажлын хэсэг гэрээний хэрэгжилтэнд хяналт тавина.

### **Тав.Гэрээний хэрэгжилт**

5.1.Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2.Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 02 дугаар сарын 01-ний дотор аймаг, сумын ИТХ-д хүргүүлнэ.

5.3.Талууд гэрээний тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймгийн Засаг дарга болон Геологи уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

### **Зургаа. Гэрээний хариуцлага**

6.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

6.3 Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд шүүхэд хандах үндэслэл болно.

6.4 Энэхүү гэрээний 3.7.1 дахь заалтыг биелүүлээгүй тохиолдолд алданги тооцож шүүхэд хандах үндэслэл болно.

### **Долоо. Маргааныг шийдвэрлэх**

7.1.Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

### **Найм. Гэрээ хүчин төгөлдөр болох, хугацаа**

8.1.Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 3 жилийн хугацаанд гэрээ хүчин төгөлдөр байна. Гэрээний хугацаа 2021.05.01-2021.12.31 дуустал хугацаанд үйлчилнэ.

8.2.Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3.Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4.Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэнэ сумын Засаг дарга, сумын Засаг даргын Тамгын газрын дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний хувийг хадгална.


8.5.Гал түймэр, цахилгаан бусад техник хэрэгслийн саатал, үер, хүчтэй аадар бороо, мөндөр, салхи шуурга, газар хөдлөлт, төр засгийн шийдвэр, онц байдал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гоц халдварт өвчний улмаас тогтоосон хөл хорио гэх мэт Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэвийн үйл ажиллагааг саатуулж, олборлолтын хэмжээг бууруулж, Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санхүүгийн чадавхид нөлөөлж болзошгүй хүчин зүйлс бий болсон тохиолдолд гэрээний үүргийн

биелэлтийг уг нөхцөл байдлыг даван туултал талууд тохиролцсоны үндсэн дээр хойшлуулж болно.

### ГЭРЭЭНИЙ ТАЛУУД

**Завхан аймгийн Ургамал сумыг**  
төлөөлж:

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫНТАЗРЫН

ДАРГА  М.ӨСӨХБАЯР


Албан ёсны хаяг: Завхан аймаг Ургамал

сум Хүнгий 4-р баг

Утас: 88015037

**Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг**  
төлөөлж:

ТҮҮЧЭЭ ТЭРЭГ" ХХК-ИЙН ЕРӨНХИЙ

ЗАХИРАЛ  С.ДАГВАСАМБУУ

Албан ёсны хаяг: Завхан аймаг

Ургамал сум Тосгуур 1-р баг

Улаанбаатар хот: БГД-ын 3  
хороо, 2-р хороололын 70-р байрын 57  
тоот

Утас: 89118883 /